



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/538

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Мөнгөн цэлмэг" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Нүүдлийн авто зам засвар /Буянт сум/ 2 дугаар багц ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б. Ганзориг

- Мэргэжлийн хяналтын авто замын хяналтын улсын байцагч

Б.Бурмаа

- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж

- Аймгийн Архивын тасгийн дарга

С.Өнөржаргал

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Ч.Нэргүй

- Буянт сумын Засаг дарга

Д.Хүрэлбаатар - "Мөнгөн цэлмэг" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2.

2. “Мөнгөн цэлмэг” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Нүүдлийн авто зам засвар /Буянт сум/ 3 дугаар багц ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН